

Жаран есдугээр зүйл

Гэрч, шинжээч нарын халдашгүй

ЭЖ

1. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн шуухийн гардуулсан урилгаар Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн байгууллагад иргэний болон гэр бул, эруугийн хэргийн талаар ирсэн гэрч, шинжээчийг аль ч улсын харьяат байсныг харгалзахгүй Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн хил нэвтрэн орохоос өмнө уйлдсэн эруугийн хэрэгт мөрдөх, баривчлах буюу мөн шуухээс урьд гаргасан таслан шийдвэрлэх тогтоолоор тэдэнд ял эдуулк хэрхэвч болохгүй.

Дээр дурдсан хумууст тэдний хил нэвтрэн орохоос өмнө уйлдсэн хуулийн бусад зөрчилд эруу уусгэж болохгүйгээс гадна уг зөрчилд ямар нэг арга хэмжээ авахгүй. Туунчлэн дурдсан хумуусийг уг шийдвэрлэж байгаа эруугийн хэрэгт холбогдуулан гэрч буюу шинжээчдээр байцаагдсаны хувьд мөрдөх буюу баривчилж болохгүй.

2. Гэрч, шинжээчдийг ируулэх хусэлт язүүлж байгаа байгууллагаас тэднийг наашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор бололцоо байсаар байтал хусэлт тавьсан Хэлэлцэн Тохирогч Этгээдийн нутаг дэвсгэрээс тэд яваагүй бол энэ зүйлийн I дэх ангид заасан халдашгүй эрхээ алдана. Гэрч, шинжээчид даалгс.вар өгч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн нутгаас гараагүй саатсан нь тэдний буруу биш бол тэр саатсан хоногийг дээрх хугацаанд оруулахгүй.

3. Шуухэд дуудагдсан дээрх хумуус замык зардал болон гадаадад байсны зардал б\тоу аваагүй палин хөлс, мөн.шинжээчийн хөлсийг нэхэмжлэх эрхтэй. Зарлан дуудах хуудсанд энэ хумуус ямац шагнул авах эрхтэй, тэдний хусэлтээр урьдчилгааг олгох тухай заасан байвал зохино.